

ДОРНОД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНЫ 05 ДУГААР САРД БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ
ЗӨРЧЛИЙН ГАРАЛТ, ТҮҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АНХААРАХ АСУУДЛУУДЫН
ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2022.05.31

Хэрлэн сум

НЭГ. ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Цагдаагийн байгууллагад иргэд, хуулийн этгээд гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2229 гомдол мэдээлэл хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 418 буюу 23 хувиар өссөн байна. Нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 726 буюу 32.5 хувийг гэмт хэргийн шинжтэй, 1503 буюу 67.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сард 191 холбогдогчтой, 709.1 төгрөгийн хохиролтой, 273 гэмт хэрэг бүртгэгдэж, 41 хэргээр буюу 17.6 хувиар урьд оны мөн үеэс өссөн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 46.2 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 22.8 хувиар өсчээ. Гэмт хэргийн улмаас 2 хүн нас барж, 123 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн 5 буюу 71.4 хувиар буурч, гэмтсэн хүний тоо 36 буюу 41.3 хувиар өссөн байна. Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 209.3 төгрөг буюу 29 хувийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэргийн гаралт:-Хэрлэн сумын 1, 2, 6, 7,8, 10 дугаар багууд, Баяндун, Дашбалбар, Баянтүмэн, Гурванзагал, Булган сумдуудад өсөж,

Хэрлэн сумын 3, 9, 11 дүгээр багууд, Чойбалсан, Сэргэлэн, Цагаан-Овоо, Баянтүмэн, Хөлөнбуйр, Баян-Уул сумдад буурч, Хэрлэн сумын 4, 5-р багууд, Матад, Халхгол сумдад урьд оны мөн үетэй ижил түвшинд байна.

Хэргийн төрлөөр: - Хүнийг алах 3 бүртгэгдэж 1 буюу 50%, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 123 бүртгэгдэж 32 буюу 35.1 хувь, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2 дахин, хулгайлах гэмт хэрэг 44 бүртгэгдэж 12 буюу 37.5 хувь, залилах гэмт хэрэг 30 бүртгэгдэж 11 буюу 57.8 хувь, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 1 дахин, нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 4 бүртгэгдэж 3 буюу 3 дахин, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг 1 буюу 100 хувь, бусад төрлийн гэмт хэрэг 14 бүртгэгдэж 12 буюу 6 дахин өсөж,

Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 2 дахин,бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 10 бүртгэгдэж 5 буюу 50 хувь, халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг гэмт хэрэг 5 бүртгэгдэж 4 буюу 80 хувь, ээрэмдэх гэмт хэрэг 2 дахин, хөрөнгө завших гэмт хэрэг 7 бүртгэгдэж 2 буюу 28.5 хувь, гээгдэл эд зүйл, алдуул мал завших гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 33.3 хувь, мансууруулах эм сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах 1 дахин, хууль бусаар ан агнах 1 буюу 100 хувь тус тус буурч,

хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 7 ижил түвшинд байна.

Хүний амь насыг болгоомжгүй хохироох, хүүхдийн эсрэг, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах, авлигын эсрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг,цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүд бүртгэгдээгүй байна.

Хулгайлах гэмт хэрэг 44 бүртгэгдсэн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12 буюу 37.5 хувиар өсөж үүнээс: хувийн өмчийг хулгайлах гэмт хэрэг 34 бүртгэгдэж 7 буюу 25.9 хувиар өсөж, Мал хулгайлах гэмт хэрэг 22 бүртгэгдэж 16 буюу 42.1 хувиар буурч мал хулгайлах гэмт хэргийн илрүүлэлт 18.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 9 хувиар өссөн байна.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 71 бүртгэгдэж 34 буюу 91.8, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 18 бүртгэгдэж 8 буюу 80%, галт зэвсэгээр үйлдэгдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж 100 хувь, хүүхэд оролцсон гэмт хэрэг 12 бүртгэгдэж 11 дахин тус тус өсөж

Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг хэрэг 11, мансуурсан үедээ үйдсэн гэмт хэрэг 1 бүртгэгдэж ижил түвшинд, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 12 хүн холбогдсон нь 12 буюу 50 хувь, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж 5 буюу 35.1 хувиар тус тус буурсан

Үйлдэгдсэн газраар: - Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 28 бүртгэгдэж 1 буюу 3.7 хувь, олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 21 бүртгэгдэж 17 буюу 4.2 дахин, Байгууллага аж ахуй нэгжид үйлдэгдсэн гэмт хэрэг 15 бүртгэгдэж 2 буюу 15.3 хувь, хөдөө хээр үйлдэгдсэн гэмт хэрэг 24

бүртгэгдэж 6 буюу 33.3 хувь,бусад газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 54 бүртгэгдэж 14 буюу 35 хувь тус тус өссөн байна.

Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 95 бүртгэгдэж ижил түвшинд байна.

Төрийн байгууллагад үйлдэгдсэн гэмт хэрэг 3 бүртгэгдэж 1 буюу 33.3%, Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 3 буюу 50%, бэлчээрт үйлдэгдсэн гэмт хэрэг 26 бүртгэгдэж 85 буюу 19.2 хувиар тус тус буурчээ.

Үйлдэгдсэн цаг хугацаагаар нь: 22-06 цагийн хооронд 78 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 33.1%, 06-14 цагийн хооронд 44 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 18.7%, 14-19 цагийн хооронд 76 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 32.3%, 19-22 цагийн хооронд 37 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 15.7%-ийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 39 буюу 16.6 хувийг Даваа гарагт, 32 буюу 13.6 хувийг Мягмар гарагт, 35 буюу 14.8 хувийг Лхагва гарагт, 31 буюу 13.1 хувийг Пүрэв гаригт, 38 буюу 16.1 хувийг нь Баасан гарагт, 31 буюу 13.1 хувийг Бямба гарагт, 29 буюу 12.3 хувийг нь Ням гарагт тус тус үйлдэгджээ.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг байршлаар нь. Хэрлэн сумы 3 дугаар баг, Булган, Сэргэлэн, Хөлөнбуйр, Матад, Чойбалсан, Халх гол сумдад тус бүр 1 буюу 1.4 хувь, Хэрлэн сумын 7,9-р багууд Баянтүмэн суманд 2 буюу 2.8 хувь, Хэрлэн сумын 11-р баг Гурванзагал, Баян-Уул, Дашбалбар сумдад 3 буюу 4.2 хувь, Хэрлэн сумын 1, 4, баяндун суманд 4 буюу 5.6 хувь, Хэрлэн сумын 2 дугаар багт 7 бүртгэгдэж 9.8 хувь, Хэрлэн сум 6 дугаар баг дээр 17 буюу 23.9 хувь, 10 дугаар баг дээр 10 буюу 14 хувь бүртгэгдсэн байна.

Согтуугаар бүртгэгдсэн гэмт хэргийн 59 буюу 83 хувь нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, 1 буюу 1.4 хувь нь хүчиндэх, хүнийг алах гэмт хэрэг 2 буюу 2.8 хувь, иргэдийн өмчийн хулгай, бусад төрлийн гэмт хэргүүд 4 буюу 5.6 хувийг эзлэж байна.

ХОЁР. ЗӨРЧИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Аймгийн хэмжээнд 2022 оны 5 дугаар сард 8765 зөрчил илрүүлсэн нь 4071 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 86.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт 7931 иргэнийг 485227.5 төгрөгөөр торгож, 601 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 38 иргэний шүүгчийн шийдвэрээр 7-30 хоногийн хугацаатайгаар баривчлах шийтгэл оногдуулсан байна. Согтууруулах ундаа хэрэглэн зөрчил гаргасан 1220 иргэнийг эрүүлжүүлсэн нь 186 буюу 1 %-иар буурсан байна.

Зөрчлийн үйлдэгдсэн цаг хугацаа, гарагийг нийт зөрчилд эзлэх хувиар:

- | | |
|----------------------------------|--------------------------------|
| - Даваа гарагт 1325 буюу 15.1%, | - Баасан гарагт 1234 буюу 14%, |
| - Мягмар гарагт 1359 буюу 15.5%, | - Бямба гарагт 1052 буюу 12%, |
| - Лхагва гарагт 1328 буюу 15.1% | - Ням гарагт 1207 буюу 13 %, |
| - Пүрэв гарагт 1260 буюу 14.3%, | |
| - 06-12 цагт 1133 буюу 12.9 % | - 19-24 цагт 2499 буюу 28.5%, |
| - 13-18 цагт 4959 буюу 56.5%, | - 01-05 цагт 174 буюу 1.9%. |

Үйлдэгдсэн онцлогоор нь:

- | | |
|-----------------------------------|----------------|
| • Согтуугаар үйлдэгдсэн | 679 буюу 7.7% |
| • Гэр бүлийн хүчирхийллийн улмаас | 70 буюу 0.7% |
| • Эмэгтэй хүн оролцсон | 4 буюу 0.01% |
| • Харьяалалгүй иргэн | 0 буюу 0% |
| • Урьд ял шийтгэгдсэн | 0 буюу 0% |
| • Хүүхэд оролцсон | 1 буюу. 0.001% |

Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн үедээ зөрчил гарган 1220 иргэн саатуулагджээ. Үүний 80 буюу 6.5% нь эмэгтэй, 3 буюу 0.2% нь насанд хүрээгүй хүн эзлэж байна.

нийгмийн байдлаар нь:

- | | |
|-----------------------------|-----------------------------|
| • Ажилгүй | 1199 буюу 98.2% |
| • Төрийн албан хаагч | 6 буюу 0.4% |
| • Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 9 буюу 0.9% |
| • Ажилчин, малчин | 1 буюу 0.01% |
| • Бусад | 2 буюу 0.01%-г эзэлж байна. |

Эрүүлжүүлэгдсэн шалтгаанаар нь:

- Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан **869 буюу 71.2%**
- Гэмт хэрэг, зөрчилд холбогдсон 21 буюу 1.7 %
- Тээврийн хэрэгсэл согтуугаар жолоодсон 42 буюу 3.4%
- Хаана байгаагаа, очих газраа мэдэхгүй болсон 39 буюу 3.1 %
- Гэмт хэрэг зөрчилд өртөж болзошгүй 222 буюу 18.1%
- Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 27 буюу 2.2%

Эрүүлжүүлэгдсэн газраар нь:

- **Гэр, орон сууцнаас 941 буюу 77.1%**
- Гудамж талбайгаас 164 буюу 13.4%
- Байгууллага, аж ахуйн нэгжээс 32 буюу 2.6%
- Баар, цэнгээний газраас 29 буюу 2.4%
- Зочид буудлаас 35 буюу 2.8%.
- Бусад 19 буюу 1.5 % нь эрүүлжүүлэгджээ

ГУРАВ. ДҮГНЭЛТ

1. Бүртгэгдсэн гэмт хэргийн 26%, зөрчлийн 45.1%-ийг согтуугаар, гэмт хэргийн 1 %, зөрчлийн 4.1%-ийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгджээ.

2. Нийт гэмт хэргийн 33.3 хувь нь 14-19 цагт, зөрчлийн 56.9% нь 13-18 цагт тус тус бүртгэгдэж, гэмт хэргийн 16.1% нь Ням, зөрчлийн 15.2% нь тус бүр Даваа гаригт үйлдэгджээ.

3. Гэмт хэргийн 34.7%, зөрчлийн 10.7%, саатуулсан хүний 77.1% нь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

4. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийн 83 % нь хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүлжүүлэгдсэн хүний 71.2%-ийг бусдын амгалан тайван байдлыг алдагдуулсан зөрчил эзэлж байгаа ба, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн зөрчлийн 1.2 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

5. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, залилах, хууль бусаар мод бэлтгэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, Хууль бусаар ашигт малтмал олборлох, эрүүл мэндийн эсрэг, иргэдийн өмчийн хулгайн гэмт хэргүүд тус тус өссөн байна.

ДӨРӨВ: ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

1. 2022 оны эхний 5 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 26 хувийг согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг эзлэж байна. Цаашид согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг өссөх хандлагатай байгаа тул урьдчилан сэргийлэх ажил хариуцсан мэргэжилтэн, баг, сум хариуцсан алба хаагчид согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийг буруулах чиглэлээр нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах.
2. Насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг урьд оны мөн үетэй харьцуулахад 3 дахин хувиар өссөн байх тул гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч нар энэ төрлийн гэмт хэргийн хохирогч, холбогдогч болохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад яриа таниулга хийж ажиллах.
3. Баг хариуцсан хэсгийн байцаагч нараас багийн хэмжээнд өссөн хэрэгт дүн шинжилгээ хийж, урьдчилан сэргийлэх ажлыг зөв оновчтой зохион байгуулах.
4. Залилах гэмт хэрэг 30 буюу 57.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Иргэд олон нийтийн цахим хэрэглээ ихсэж онлайн хэлбэрээр бусдад залилуулах, хохирогч болох эрсдэлтэй байгаа тул энэ төрлийн гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил арга хэмжээг зохион явуулах.
5. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 91.8 хувиар өссөнд дүн шинжилгээ хийхэд улс, аймгийн хэмжээнд хорио цээрийн дэглэмийг цуцлаж, архи согтууруулах ундаагаар үйлчилгээ явуулдаг газруудын цагийн хуваарьт өөрчлөлт оруулсантайгаар холбоотойгоор иргэдийн хөдөлгөөн, архи согтууруулах ундааны хэрэглээ ихсэж архи согтууруулах ундаагаар үйлчилдэг газруудын цагийн хуваарьт хяналт тавьж ажиллах.
6. Гудамж талбай, олон нийтийн газар, байгууллага аж ахуй нэгжүүдэд үйлдэгдсэн гэмт хэрэг 33.3-42.9 хувиар өссөн байгаад баг хариуцсан хэсгийн байцаагч нар анхаарч, зөрчлийн материал шалгах биш, хариуцсан багийн хэмжээнд урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад онцгой анхаарч ажиллах.

Та бүхний ажилд амжилт хүсье.